

Батлав: “МХБ” ТӨХК-ийн
гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч

Батлав. “.....” ХК-ийн
гүйцэтгэх захирал

.....
/ Д.АНГАР /

.....
/ /

БҮРТГЭЛИЙН ГЭРЭЭ № ...

20... оны ... дугаар
сарын -ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү үнэт цаас гаргагчтай байгуулах гэрээг нэг талаас "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК, түүнийг төлөөлж Арилжаа, хяналтын албаны захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Мөнхтуяа /цаашид МХБ гэх/ нөгөө талаас “.....” ХК /цаашид үнэт цаас гаргагч гэх/, хамтад нь /цаашид талууд гэх/ харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулав.
- 1.2 Талуудын хооронд үүсэх харилцааг “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”, “Компанийн тухай хууль” болон холбогдох бусад хууль тогтоомж, Санхүүгийн Зохицуулах Хороо /цаашид СЗХ гэх/, МХБ-ээс баталсан журам, заавар болон энэхүү гэрээгээр зохицуулагдана.
- 1.3 МХБ нь бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн гаргасан төгрөгийн нэрлэсэн үнэтэй ширхэг, нийт / / төгрөгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэнэ.
- 1.4 Гэрээ нь талууд харилцан гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, үнэт цаас гаргагч нь МХБ-ийн бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно.

Хоёр. ГЭРЭЭНД ТУСГАГДСАН НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

- 2.1. Энэхүү гэрээнд заасан нэр томъёог дараах утгаар ойлгоно:
 - 2.1.1. “Хувьцаа эзэмшигчийн эрх” гэж Компанийн тухай хуулийн 5 дугаар бүлэгт заасан болон холбогдох бусад хууль тогтоомжоор олгогдсон эрхийг;
 - 2.1.2. “Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах хугацаа” гэж Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрт заасан хугацааг;
 - 2.1.3. “Хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг хөндсөн асуудал” гэж Компанийн тухай хуулийн 4, 7, 11, 12 дугаар бүлэгт заасан асуудлуудыг;
 - 2.1.4. “МХБ-ийн журам, заавар” гэж үнэт цаасны арилжаа, бүртгэл, хяналт шалгалт, мэдээлэл түгээх, гишүүнчлэл зэрэг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын үндсэн үйл ажиллагааг зохицуулж буй журам, заавруудыг;
 - 2.1.5. “Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл” гэж өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ цацдаг радио, телевиз, компанийн болон хөрөнгийн биржийн цахим хуудсыг;

2.1.6. “Олон нийтэд мэдээлсэн” гэж мэдээллийг хоёроос доошгүй өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлэгээ цацдаг радио, телевиз болон МХБ-ийн цахим хуудсаар нийтэлснийг;

2.1.7. “Зарласан хувьцаа” гэж Компанийн тухай хуулийн 33 дугаар зүйлд зааснаар компанийн дүрмээр тогтоосон энгийн болон давуу эрхийн хувьцааг;

2.1.8. “Эргэлтэнд гаргасан хувьцаа” гэж Компанийн тухай хуулийн 33.2 дугаар зүйлд зааснаар зарласан хувьцаанаас хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн хэсгийг.

Гурав. МХБ-ИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. МХБ нь дараах эрхтэй.

3.1.1. Шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг бүртгэлтэй үнэт цаас гаргагчаас гаргуулан авах,

3.1.2. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хөндсөн аливаа асуудлаар үнэт цаас гаргагчаас тайлбар, тодруулга шаардан авах,

3.1.3. Бүртгэлтэй үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээ, мэдээллийг олон нийтэд мэдээлэх, үнэт цаас гаргагчдад мэдээллийг олон нийтэд хүргэх талаар шаардлага тавих,

3.1.4. Бүртгэлтэй үнэт цаас гаргагч үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомжийг зөрчсөн, МХБ-ээс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд олон нийтэд мэдээлэх,

3.1.5. Бүртгэлтэй үнэт цаас гаргагчдад үзүүлэх үйлчилгээний хөлсийг нэхэмжлэх,

3.1.6. Бүртгэлтэй үнэт цаас гаргагчийг “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 20 болон 56-р зүйлд заасан нийтлэг үүргээ биелүүлэн ажиллах талаар шаардлага тавих,

3.1.7. Бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь хууль, дүрэм, журам зөрчсөн нь баримтаар нотлогдсон тохиолдолд эрүүгийн хариуцлага болон захиргааны шийтгэл ногдуулахааргүй бол МХБ-ийн “Бүртгэлийн журам”-ын 25-р зүйлд заасны дагуу арга хэмжээ авах,

3.1.8. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд үнэт цаас гаргагчийн бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаанд холбогдох журам, удирдамжийн дагуу тусгай шалгалтыг хийх,

3.1.9. Хууль, дүрэм журамд заасан бусад эрх эдлэх,

3.2. МХБ нь дараах үүрэгтэй.

3.2.1. Үнэт цаас гаргагчийн гаргасан хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэж, өөрчлөлтийг тухай бүр хөтлөн үнэт цаасны арилжааг зохион байгуулах ажиллагааг зохих дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэх,

3.2.2. Бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн хүсэлтээр хөрөнгийн зах зээлтэй холбоотой асуудлаар зохих журам, шийдвэрийн хүрээнд зөвлөгөө, зааварчилгаа өгөх, сургалт, семинар зохион байгуулах,

3.2.3. МХБ-ийн журам, зааварт өөрчлөлт орсон нөхцөлд энэ талаар болон шаардлагатай мэдэгдэл, мэдээллийг үнэт цаас гаргагчдад өөрийн цахим хуудсаар, цахим шуудангаар эсхүл албан бичиг, харилцаа холбооны бусад хэрэгслээр мэдэгдэх,

3.2.4. Үнэт цаасны бүртгэл, арилжаатай холбоотой мэдээ, судалгааг зохих журмын дагуу үнэт цаас гаргагч компанийн хүсэлтээр гаргаж өгөх,

3.2.5. Үнэт цаасны арилжаанд хяналт тавих, тодорхой чиглэл удирдамжийн дагуу шалгалт хийх,

3.2.6. Шалгалтаар зөрчил илэрсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага болон захиргааны шийтгэл ногдуулахааргүй бол хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд олгогдсон эрх хэмжээний дагуу арга хэмжээ авах,

3.2.7. Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хөндсөн асуудлаар бүртгэлтэй үнэт цаас гаргагчаас гаргасан аливаа шийдвэр нь хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд шалгалт хийх,

3.2.8. Бүртгэлтэй үнэт цаас гаргагчаас олон нийтэд мэдээлэхээр ирүүлсэн үйл ажиллагааны талаарх мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдээлэх.

Дөрөв. БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь дараах эрхтэй.

4.1.1. Үнэт цаас бүртгүүлэх, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасуулах тухай өргөдөл гаргах,

4.1.2. Бүртгэгдсэн үнэт цаасыг СЗХ-ны зөвшөөрлийн дагуу анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаанд оруулах хүсэлт гаргах,

4.1.3. Бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурал хуралдуулах, үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулахтай холбоотой асуудлаар МХБ-ээс заавар, зөвлөмж авах,

4.1.4. Үнэт цаасны бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар МХБ-д санал хүсэлт гаргах, журамд заасан хугацаанд үндэслэл бүхий хариу авах, шийдвэрлэх асуудлаар харилцан зөвшилцөх,

4.1.5. Зохих нөхцөл бүрдсэн тохиолдолд бүртгэлтэй компанид үзүүлэх үйлчилгээний хөлс төлөхтэй холбоотой хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх,

4.1.6. Холбогдох дүрэм, журамд заасан нөхцлийг хангасан тохиолдолд үнэт цаасны бүртгэл, арилжаатай холбогдох мэдээлэл, судалгааг авах,

4.1.7. МХБ-ээс тавьсан хууль ёсны шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд энэ тухай МХБ-д шалтгаан бүхий тайлбарыг нэн даруй бичгээр хүргүүлэх,

4.1.8. Үнэт цаас гаргагчтай холбоотой МХБ-ээс гаргасан шийдвэрийн талаар аливаа гомдолыг МХБ-ийн “Бүртгэлийн журам”-ын 26 дугаар зүйлд заасны дагуу гаргах.

4.2. Бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь дараах үүрэгтэй.

4.2.1. Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 болон 56-р зүйлд заасан нийтлэг үүрэг болон МХБ-ийн “Бүртгэлийн журам”-ын 17, 18 дугаар зүйлд заасан тогтмол биелүүлэх үүргийг бүртгэлтэй байх хугацаандаа биелүүлж ажиллах,

4.2.2. Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай тухай хууль, СЗХ, МХБ-ийн журам заавруудыг дагаж мөрдөн хувьцаа эзэмшигчдээс хуулиар олгогдсон эрхийн хүрээнд тавьсан шаардлагыг биелүүлж ажиллах,

4.2.3. МХБ, түүний үнэт цаасны бүртгэл болон хяналт хариуцсан ажилтнаас тавьсан шаардлагыг биелүүлэх, мэдээ, судалгаа, тайлбар, тодруулгыг гаргаж өгөх, үнэт цаас худалдах замаар хуримтлуулсан хөрөнгийн зарцуулалттай холбоотой асуудлын хүрээнд шалгуулах,

4.2.4. Өөрийн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад шудрага, тэгш хандах,

4.2.5. Дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчим /кодекс/-ыг дагаж мөрддөг байх, хэрэв мөрддөггүй бол энэ тухай тайлбар гаргаж МХБ-д мэдэгдэх ба олон нийтэд мэдээлэх,

4.2.6. Бүртгэлтэй байх хугацаанд МХБ-ийн “Бүртгэлийн журам”-д заасан үнэт цаасны зохих ангиллын шалгуурыг хангаж ажиллах,

4.2.7. Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад болон МХБ-д мэдээлэл хүргэх талаар дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

1. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль, журмын дагуу хөрөнгө оруулагчдад хүргэхээр заасан мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж, олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр мэдээлэх ба МХБ-д мэдэгдэх,
2. МХБ-ийн “Бүртгэлтэй компаниудаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх заавар”, мэдээлэл түгээхтэй холбоотой бусад журам, зааварт тусгасан мэдээллийг заасан хугацаанд цахим хэлбэрээр болон хэвлэмлээр МХБ-д хүргүүлэх,
3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн тавдугаар бүлэгт тусгасан анхдагч ба хоёрдогч зах зээлийн мэдээллийг СЗХ, МХБ-д бичгээр болон цахим хэлбэрээр хүргэх, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх,
4. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу үнэт цаасны үнэ ханшид нөлөөлж болох, үнэт цаасны арилжаанд оролцоход давуу тал олгох нийтэд тараагдаагүй мэдээллийг хөрөнгө оруулагч бусад этгээдэд нэгэн зэрэг, тэгш хүргэх,
5. Үнэт цаасны ханшид нөлөөлөх аливаа мэдээллийг дараа өдрийн арилжаанаас өмнө олон нийтэд мэдээлж, энэ тухай МХБ-д мэдэгдэх,
6. Олон нийтээс татсан хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг бүрэн хэрэгжүүлэх хүртэл хугацаанд түүнийг хэрэгжүүлэхэд зориулж татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт, төслийн гүйцэтгэлийн тайланг хагас жил тутамд гаргаж, дараа сарын 15-ны дотор МХБ-д ирүүлэх,
7. Үнэт цаасны дэлгэрэнгүй танилцуулга, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, үнэт цаастай холбоотой бичгийн цаасны 2 нүүрээс дээш хэмжээтэй бүх мэдээллийг МХБ-д хэвлэмлээр болон цахим хэлбэрээр ирүүлнэ.

4.2.8. Үнэт цаас гаргагч нь МХБ-д бүртгэлтэй байх хугацаанд МХБ-ийн “Бүртгэлийн журам”-ын 24.13 дугаар зүйлд заасан хугацаанд багтаан бүртгэлтэй компанийн жилийн үйлчилгээний хөлс төлөх,

4.2.9. Үнэт цаас гаргагч нь шинээр болон нэмж үнэт цаас бүртгүүлэх, бүртгэлд өөрчлөлт оруулах тохиолдолд өргөдлийг хүлээн авч хянах үйлчилгээний хөлс, үнэт цаасыг бүртгэх үйлчилгээний хөлсийг төлөх,

4.2.10. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны зах зээл дээр мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, заавар, гэрээний үүргийн биелэлттэй холбогдуулан МХБ-ээс тавьсан шаардлагыг биелүүлж хариу мэдэгдэнэ. Гэрээний 4.1.8-д заасны дагуу тайлбар ирүүлээгүй нөхцөлд шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

Тав. ХАРИУЦЛАГА

- 5.1. Үнэт цаас гаргагч нь гэрээний 4.2 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд эрүүгийн хариуцлага болон захиргааны шийтгэл ногдуулахааргүй бол МХБ-ийн зүгээс хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд олгогдсон эрх хэмжээний дагуу арга хэмжээ авна.
- 5.2. Мэдээллийн үнэн зөвийг мэдээлэл гаргагч талууд хариуцна.
- 5.3. Үнэт цаас гаргагч нь гэрээний 4.2.7-ын 2-т заасан үүргээ зөрчсөн тохиолдолд Иргэний хуулийн 232.5-д заасны дагуу мэдээний төрөл бүрт 100 000 төгрөгийн торгуулийг МХБ-д төлнө.
- 5.4. Энэхүү гэрээний 4.2.8, 4.2.9, 5.3 дугаар зүйлд заасан үйлчилгээний хөлс болон торгуулийг заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд МХБ-ийн “Бүртгэлийн журам”-ын 25.2 дугаар зүйлд заасны дагуу алданги тооцно.
- 5.5. Үнэт цаас гаргагчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан үнэт цаасны арилжааг зогсоох болон бусад арга хэмжээтэй холбогдон хувьцаа эзэмшигч, бусад этгээдэд учирсан хохирлыг МХБ хариуцахгүй.
- 5.6. Үнэт цаасны танилцуулга, холбогдох баримт бичигт худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, зөрүүтэй, алдаатай мэдээлэл тусгасны улмаас бусдад хохирол

учруулсан бол уг хохирлыг “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 9.14-р зүйлд заасны дагуу үнэт цаас гаргагч, уг шийдвэрийг гаргасан эрх бүхий албан тушаалтан хамтран хариуцна.

Зургаа. БУСАД

- 6.1. Гэрээг хоёр хувь үйлдэн талуудад хадгалуулах бөгөөд хувиуд адил хүчинтэй.
- 6.2. Талуудын хүсэлтээр харилцан тохиролцож гэрээнд өөрчлөлт оруулж болно.
- 6.3. Талуудын хооронд гарсан маргааныг талууд харилцан зөвшилцөж, үл маргах журмаар шийдвэрлэнэ.
- 6.4. Хэрэв талууд гэрээтэй холбогдох маргааныг энэхүү гэрээний 6.3-т зааснаар шийдвэрлэж чадахгүй бол Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

"МХБ" ТӨХК-ийн
Арилжаа, хяналтын
албаны захирлын үүргийг
түр орлон гүйцэтгэгч

.....

/Т.Мөнхтуяа/

“.....” ХК-ийн

.....

/ /